



Европын холбооны санхүүжилттэй “Найрамдал” төслийн зорилтот төслүүдийн тайлан боловсруулах гүйцэтгэгч, үйлчилгээ үзүүлэгчийг сонгон шалгаруулах ажлын удирдамж

Үндэслэл: “Дархан-Уул аймгийн нийгэм эдийн засгийн шинэлэг тэгш хүртээмжтэй тогтвортой өсөлтийг дэмжин Европын Холбоо-Монгол Улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх Найрамдал” төслийг Европын Холбооны “EuropeAid /171273/DH/ACT Multi-2 Орон нутгийн засаглал: Тогтвортой хотуудын түншлэл 2021” хөтөлбөрт Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газар(Найрамдал төслийн зохицуулагч), ХААИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар сургууль(Хамтран ашиг хүртэгч ба түнш) болон Зүүн өмнөд Европын бүс нутгийн удирдлагын консорциум (Хамтран ашиг хүртэгч ба түнш) хамтран Дархан-Уул аймагт 2022 оны 02-р сараас эхлэн хэрэгжүүлж байна.

Найрамдал төслийн зорилт IV хүрээнд одоогоор Дархан-Уул аймагт дараах 6 зорилтот төсөл хэрэгжиж байна:

- “Ус хог хаягдал, эрчим хүч (цахим засаглал болон нийгмийн дэд бүтцийг бий болгох)” чиглэлээр шалгарсан 3 зорилтот төсөл
- Нийгэм, мэдээллийн технологийн энтрепренершип-ийг дэмжсэн 3 зорилтот төсөл, үүнд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах төслүүдийг хэрэгжүүлэх боломжит зорилтот төслийг боловсруулах мэргэжлийн/техникийн туслалцаа зэрэг багтана.

Эдгээр төслүүдийн хэрэгжилтийг хянах, үр дүнтэй хэрэгжүүлэх, зөвлөх цаашид авах арга хэмжээний талаар түншүүдэд мэдээлэл хүргэх, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаанд лавлагаа болгон ашиглах талаар төслийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.3 дах хэсэгт тодорхой заагдсан.

Төслийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг <http://eudarkhan.mn/>, **FB: Найрамдал төсөл / Friendship project** хуудаснаас үзнэ үү.

Зорилго: Зорилтот төслүүдийн үйл явцад дүн шинжилгээ хийж үр дүн хэрэгжилтийг сайжруулах, хянах, тайлан боловсруулахад чиглэнэ. Зорилтот төслийн хэрэгжилтийн үр дүнгийн тайланг боловсруулахад чиглэнэ.

Зорилтот төслүүдийн тайлан нь (ЗТТ) нь тогтвортой хотуудын зорилгын хүрээнд хотын байгаль орчны нөхцөл байдал, нийт иргэдийн нийгмийн сайн сайхны төлөөх хөгжил дэвшил, инновацын замыг бий болгох үндэс суурь болох засаглал, нийгмийн оролцоо, тэсвэртэй байдал, ногоон хөгжлийн арга барилыг харуулахад чиглэсэн хэрэгжих боломжтой төслийн санаа бүхий тогтвортой, ногоон, ухаалаг хотыг хөгжүүлэхэд чиглэсэн эмхэтгэл, гарын авлага болно.

Зорилтот төслүүдийн тайланд Дархан хотыг тогтвортой хот болгон хөгжүүлэхэд чиглэсэн техникийн дүн шинжилгээ, оролцогч талуудын зөвлөлдөх уулзалтууд болон тодорхой үйл ажиллагаануудыг тусгаж боловсруулсан байна. **Тогтвортой хотын зорилтот төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс** гарсан үр дүн нь санхүүжилт татах боломжтой томоохон хөрөнгө оруулалтын төслийг боловсруулах, төслийн бэлтгэл ажлыг хангах, хөрөнгө оруулалтын сан бүрдүүлэхэд шаардлагатай техникийн туслалцааны үндэс суурийг тавина.



Хэрэгжүүлэх үйл ажиллагааны агуулга:

Уг тайланд зорилтот төслүүдийг хэрэгжүүлэхэд мөрдсөн стандарт, үйл ажиллагааны журам, ажлын хэсгийн гаргасан шийдвэр, протокол, хяналт-шинжилгээ, дагаж мөрдсөн үнэлгээний систем, хаалтын тайлан зэргийг бүрэн гүйцэд тусгасан байна. Мөн зорилтот төслийн удирдлагын систем, тайлагнахтай холбоотой зохицуулалт зэргийг тусгана.

Хүлээгдэж буй үр дүн: Энэхүү тайлан нь Европын Холбоо болон бусад олон улсын түншүүдтэй хамтарсан үйлдвэр байгуулах, цаашдын хамтын ажиллагааны дотоод болон гадаад гол шалгуур болно. Дархан хотын зорилтот төслүүдийн хэрэгжилтийн тайлан нь цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаанд лавлагаа болгон ашиглагдана.

Ажлын гүйцэтгэгчийг сонгох: Төслийн зорилт IV үйл ажиллагааны 4.3 заагдсан ажил үйлчилгээг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэхээр төлөвлөж байна. Шалгаруулалтыг Европын холбооны худалдан авах ажиллагааны стандартыг баримтлан зохион байгуулна. Өргөдөл гаргах боломжийг бүрдүүлж ажиллана. Шалгаруулалтыг ил тод зохион байгуулахын тулд тендерийн хороог байгуулна.

Гүйцэтгэгчийг хүрээлэн буй орчин, уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой хөгжил зэрэг сэдвүүдийн хүрээнд хот төлөвлөлт, тэсвэртэй байдал, эрсдэлийг бууруулах, дасан зохицох болон бусад ижил төстэй чиглэлүүдээр ажиллаж байсан туршлагатай, хувь хүн эсвэл байгууллагаар төлөөлүүлэн оролцож буй мэргэжилтнүүдийн үндсэн мэдлэг, туршлагад үндэслэн сонгоно. Мөн тэтгэлэг болон хөрөнгө оруулалтын төсөл боловсруулах, олон түвшний засаглалын хүрээнд хотын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх чадвартай техникийн мэргэжилтнүүд байвал давуу тал болно.

- **Баг /консорциум/ нь Европын холбоотой хамтарсан баг бол давуу тал болно.**

Шалгаруулалтад оролцогч: Тус чиглэлээр мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай хуулийн этгээд, зөвлөх багтай хамтарч ажиллана. Энэхүү ажлын даалгаварт сонгогдох зөвлөх нь орон нутгийн засаг захиргааны тэтгэлэг болон төслийн саналын баримт бичиг, концепц боловсруулах туршлагатай хүмүүсээс сонгогдоно. Зөвлөхүүд орон нутгийн засаг захиргаа, хотуудын холбоотой хамтран ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно. Зорилтот төслүүдийн тайланг орон нутгийн, аймгийн болон бүс нутгийн түвшинд тогтвортой хотын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх гарын болгон боловсруулж өгөхөд чиглэнэ.

Ажлын даалгавар

Тайлангийн гол үүрэг

- Төслийн хэрэгжилтийн явцад дүн шинжилгээ хийх
- Тендер, нээлттэй өрсөлдөөний зарчмаар хэрэгжүүлсэн зорилтот төслүүдийн ололт амжилт, алдаа дутагдлыг тодорхойлох
- Ирээдүйн төслүүдийг хэрэгжүүлэхэд баримтлах бодлого, арга хэмжээг боловсруулах санал, зөвлөмж гаргах

Тайланг бүрдүүлэхэд шаардлагатай баримт бичиг



- Тендерийн бүх хороодын гаргасан шийдвэр, протокол
- Төслийн хяналт, шинжилгээний тайлан, дагаж мөрдсөн үнэлгээний систем
- Хаалтын тайлан болон зорилтот төслийн удирдлагын системийн мэдээлэл
- Тайлагнахтай холбоотой холбогдох журам, зохицуулалтууд

Тайлан боловсруулах үе шат

Урьдчилсан бэлтгэл

- Төслийн баримт бичгүүд болон холбогдох мэдээллийг цуглуулах
- Баг бүрдүүлж, бүрэлдэхүүнийг баталгаажуулах

4.2 Тайлангийн бүтэц боловсруулах

Тайлан дараах хэсгүүдээс бүрдэнэ:

1. Тайлангийн үндэслэл, зорилго
2. Төслийн хэрэгжилтийн дүн шинжилгээ
 - o Ололт амжилт
 - o Алдаа дутагдал
3. Зөвлөмж
4. Дүгнэлт

Баримт бичгийн боломжит бүтцийг дараах байдлаар дэлгэрэнгүй тайлбарлаж болно.

Энэхүү баримт бичгийг боловсруулах явцад уг тайлан нь бүс нутгийн хөгжил цэцэглэлтийн төлөөх хотыг тогтвортой хөгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт хандах хандлагыг боловсруулахад орон нутаг, аймаг, засгийн газрын үйл ажиллагааны иж бүрэн, уялдаа холбоотой, хэрэгжүүлэх боломжтой үйл ажиллагааны төлөвлөгөөг тусгасан байх ба уг баримт бичиг нь иж бүрэн, гэхдээ уншихад хялбар, ойлгомжтой байх ёстой.

Энэхүү баримт бичиг нь гурван үндсэн хэсгээс бүрдэнэ:

I хэсэгт Дархан-Уул аймгийн засаг даргын тамгын газрын хүрээнд Найрамдал төслийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг агуулна. Мөн энэ хэсэгт санхүүжүүлсэн зорилтот төслүүдийн суурь нөхцөл байдлыг тодруулахад чиглэсэн бүлгүүдийг багтаана.

1-р бүлэг. Арга зүй – Дархан хотод Орон нутгийн засаглал-Тогтвортой хотуудын түншлэлийг хэрхэн хэрэгжүүлж, Дархан хотын нөхцөлд хэрхэн тохируулан нийцүүлсэн талаар танилцуулна. Энэ бүлэгт хотууд хоорондын болон мэргэжил нэгтнүүдийн хамтын ажиллагааны арга барил, мөн Дархан-Европын хотуудын засгийн газар, бүс нутгууд хоорондын хамтын ажиллагааны бусад хэрэгслүүдийг хамруулна.

2-р бүлэг. Суурь үнэлгээ – Санхүүжүүлсэн зорилтот төслүүдийн хүрээнд Дархан хотын нөхцөл байдлын нарийвчилсан үнэлгээг хийх ба мэдээлэл цуглуулалт, шинжилгээний



дэлгэрэнгүй мэдээлэл, мөн төсөл эхлэхээс өмнөх нөхцөл байдалд тулгарсан саад бэрхшээлүүдийг багтаана.

II хэсэг нь техникийн үндсэн арга барилыг танилцуулж, I хэсгийн ололт дүгнэлтэд тулгуурлан боловсруулсан Тогтвортой Хотын Үйл Ажиллагааны Төлөвлөгөөг болон зорилтот төслүүдийг оновчтой сонгосон үндэслэлийг танилцуулна. Энэ хэсэг нь дараах сонгосон бүлгүүдээс бүрдэнэ.

3-р бүлэг. Дархан хотын эрхэм зорилго, алсын хараа, богино хугацааны, дунд хугацааны, урт хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөө болон стратегийн зорилтууд – Зорилтот төслүүдийг тодорхойлж, тэдгээрийг Европын Холбооны Орон нутгийн засаглал–Тогтвортой хотуудын түншлэл хөтөлбөрийн ерөнхий болон тусгай зорилготой уялдуулна. Энэ бүлэгт төслийн үйл ажиллагаа, гарц, үр дүнг нарийвчлан тайлбарлаж, Найрамдал төслийн үр дүнгийн хүснэгтийн нөлөөлөл болон үзүүлэлтийг тодорхойлох болно.

4-р бүлэг. Үйл ажиллагаанууд – Санхүүжүүлсэн зорилтот төслүүдэд тулгуурлан 4 тусгай зорилго, үйл ажиллагаа, гарцыг тодорхой зорилтот үр дүн, урьдчилсан зардал, хариуцлага, хэрэгжүүлэх алхамчилсан аргачлалтайгаар техникийн туслалцаа болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хөрвүүлэн тайлбарлана. Хотын олон бүс нутагт дахин төлөвлөлт, шинэчлэл шаардлагатай тул эдгээр үйл ажиллагаанууд нь нэгдмэл болон олон зориулалттай байхаар төлөвлөгдсөн. Энэ бүлгийг боловсруулахдаа Европын Тогтвортой Хот Хөгжүүлэх Лавлагааны хамрах хүрээ, Тогтвортой Хот Хөгжүүлэх Үр дүн ба Үзүүлэлтүүд, мөн Эдийн засгийн хамтын ажиллагаа ба хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-ын бусад аргачлалуудыг ашиглан зөвлөмж боловсруулна.

5-р бүлэг. Хяналт-шинжилгээний ерөнхий бүтэц тайлбар – Хотуудын зохицуулалтын байгууламжийн саналын ерөнхий бүтэц ЭЗХАХБ-ын (OECD) хүрээнд нийцүүлэн боловсруулсан хяналт-шинжилгээний эцсийн зорилгыг тайлбарлана.

4.3 Дүн шинжилгээ, үнэлгээ хийх

- Хяналт, үнэлгээний системийн мэдээллийг ашиглан төслийн үр дүнг дүгнэх
- Төслийн хэрэгжилтийн ололт, дутагдлыг баримттайгаар тодорхойлох

4.4 Тайлангийн төслийг боловсруулах

- Баримт нотолгоонд суурилсан товч, тодорхой бичлэгтэй тайлан гаргах
- Төслийн үйл ажиллагааны явц, үр дүн, сургамжийг тодорхой тусгах

4.5 Тайланг хянах, батлах

- Багийн гишүүд болон холбогдох албад хянаж, шаардлагатай засвар, сайжруулалт хийх
- Тайланг эцэслэн баталгаажуулж, холбогдох талуудад хүргүүлэх
- Төслийн хэрэгжилтийн талаар иж бүрэн дүн шинжилгээ хийсэн, нэгтгэсэн тайлан
- Төслийн ололт амжилт, алдаа дутагдлыг тодорхойлон, цаашид баримтлах бодлого, арга хэмжээний санал зөвлөмж
- Дархан-Уул аймаг болон Европын Холбооны хамтын ажиллагааг хөгжүүлэх үндэслэл бүхий баримт бичиг